

БАТЛАВ

НОМЫН САНГИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙН ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.НАРНАЙ

2022 оны 07 сар 30 өдөр

УСХ0010

НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ДОТООД ХЯНАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Номын сангийн үйл ажиллагаа төлөвлөлт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, албан хаагчдын ажлын зохион байгуулалт, ажлын гүйцэтгэлд дотоод хяналт хийх, зөвлөн туслах, илэрсэн зөрчлийг арилгахад чиглэнэ.

Хоёр. Үндэслэл, хамрах хүрээ

Эрх зүйн үндэслэл:

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- Уншлага үйлчилгээний үйл ажиллагаа
- Арга зүйн ажил
- Ном зүйн ажил
- Бодлогын баримт бичгүүд
- Мэдээллийн дотоод сүлжээ вэб сайт
- Шилэн данс, санхүүгийн ил тод байдал

Дотоод хяналтын хамрах хүрээ: номын сангийн үйл ажиллагаа, бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилт тэдгээртэй холбогдуулан гаргасан төлөвлөгөө тайлан, зохион байгуулсан арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Хамрагдах албан хаагчид: Нийтийн Номын Сангийн мэргэжилтнүүд

Гурав. Дотоод хяналт шалгалтын хугацаа

Хяналт, шалгалтыг 2022 оны 10 сарын 03-наас 10 сарын 05-ны өдрийн хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн А.Чимэгмаа хийж гүйцэтгэнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хяналт шалгалтыг албан хаагч бүрийн ажлын байранд, цаасан болон цахим баримтад тулгуурлан гүйцэтгэнэ.
2. Хяналтын явц, үр дүнг нотлох баримт, фото зургаар баталгаажуулна.
3. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, зөвлөгөө, зөвлөмж өгөх, хугацаатай үүрэг даалгавар өгөх
4. Дотоод хяналт шалгалтын дүн, танилцуулгыг номын сангийн захиралд танилцуулж, мэдээллийг цахим вэб хуудаст байршуулах

Тав. Дотоод хяналт, шалгалтын үр дүнг тайлагнах

Дотоод хяналт хийсэн тухай үнэлгээ, дүгнэлт, тайланг даргад 2022 оны 10 сарын 10-нд танилцуулна.

Дотоод хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавина.

Удирдамж гаргасан:



А.Чимэгмаа